



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 350


Улаанбаатар хот

┌ Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх ┐ тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн арван наймдугаар хавсралт “Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 2.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хавсралтад дурдсан нэр бүхий 20 иргэнд “Бодь даатгал” ХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгогдсон иргэдэд “Бодь даатгал” ХК-аас бусад даатгалын компанид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхгүй болохыг анхааруулсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН